

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТЭЭВРИЙН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЭРДЭНЭ-ОЧИР ТАНАА

2020.02.20 № 06/529
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тээврийн прокурорын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Тээврийн прокурорын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Тээврийн прокурорын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харъяа Тээврийн прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Тамгын газрын дарга Б.Эрдэнэ-Очир Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтыг сайжруулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харъяа Тээврийн прокурорын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харъяа Тээврийн прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 26-наас 2020 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Пантер мидланд Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харъяа Тээврийн прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний Аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 2/223 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харъяа Тээврийн прокурорын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь хүний эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах , түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх арга хэмжээ авахад оршино.

Прокурорын тухай хуулиар Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харъяа Тээврийн прокурорын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Прокурор зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих
- Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх үйл ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх
- Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх
- Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааны явцад хуулийг зөв хэрэглэж байгаа эсэх
- Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангаж байгаа эсэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Тээврийн прокурорын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тээврийн прокурорын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд 'Acolous' программ хангамж ашигладаг байна.

Тээврийн прокурорын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аудитаар Тээврийн прокурорын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 749,381.9 мянган төгрөгөөс тооцон 14,993.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 2 хувь болох 16,349.2 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд мэдээллийн хүрээнд эрсдэл дунд гэж үзэн 2 хувийг сонгосон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд онцгой өөрчлөлт гараагүйтэй холбоотой болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тээврийн прокурорын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,294.6 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,503.9	899.5	-604.4
Урьдчилгаа			
Бараа материал	12,849.9	13,655.5	805.7
Үндсэн хөрөнгө	43,750.4	45,843.8	2,093.4
Нийт хөрөнгө	58,104.2	60,398.8	2,294.6
Өр төлбөр	42.0	348.2	306.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	58,062.2	60,050.6	1,988.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	58,104.2	60,398.8	2,294.6

Авлага дансны үлдэгдэл буурсан нь хүмүүсээс авах авлагыг барагдуулснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2018 онд үүссэн 610.1 мянган төгрөгийн, 2019 онд үүссэн 289.5 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна. Энэ нь тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 805.7 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материалын худалдан авалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нэмэгдсэнээс шалтгаалжээ. Ерөнхий прокурорын газраас 12,371.3 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 1,237.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 545 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий прокурорын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/77 дугаар тушаалыг үндэслэн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 46,900.0 мянган төгрөг, акталсан хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварын ногдлыг дутуу тооцоолсоноос шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 60,050.6 мянган төгрөг болж 1,988.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 773,697.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 773,697.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдсаныг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулахад 773,697.8 мянган төгрөгийн буюу 100 хувь орлого төвлөрсөн байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулахад 153.2 мянган төгрөгийн урсгал зардал зарцуулагдаагүй үлдсэнийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 773,544.6 мянган төгрөг буюу 99.98 хувьтай байгаа нь урсгал зардлын зарцуулагдаагүй үлдсэнийг буцаан төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Засгийн газрын нөөц сан, Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу 30,000.0 мянган төгрөгийг төсвийн захирагчид хуваарилсан байна.

Үүнээс гэрэлт самбарт 7,500.0 мянган төгрөг, шторкод 9,000.0 мянган төгрөг, сурталчилгааны материалд 8,000.0 мянган төгрөг, ном, эх бэлтгэлд 5,500.0 мянган төгрөг нийт 30,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж, нийт 12 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 4,079.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,109.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,622.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 348.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд:

1. Өмнөх онд үүссэн 610.0 мянган төгрөгийн хүмүүсээс авах авлагыг барагдуулаагүй, тайлант онд нэмж 289.5 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл "Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", мөн хуулийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг бүрэн барагдуулах албан шаардлага өгөх

2. Бараа материалын тайлангаар жолоочид олгосон шатахууны болон газийн талоныг тооцоо бодолгүйгээр 1,700.0 мянган төгрөгийг шууд зарлага болгосон, 22.5 мянган төгрөгийн шатахууны хөнгөлөлтийг үнэ төлбөргүй авсан орлогоор бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4."хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ,14.4.5."бүх орлого" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Цалин хөлсний тооцооллоор 1,109.5 мянган төгрөгийн илүү цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж,

зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, мөн хуулийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 348.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Тээврийн прокурорын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 13 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, огт байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Тээврийн прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Тээврийн прокурорын газар 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: НДШ-ийн тайлангаарх үлдэгдэл санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 282.5 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ." гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хуулийг хэрэгжүүлж ажиллана

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: ХХОАТ-ын 65.7 мянган төгрөгийн ногдолыг дутуу тооцсоноос тайлант хугацаанд өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн "Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн зарчмыг хэрэгжүүлж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хэрэгжүүлж ажиллана

Тайлант хугацаанд хугацаанд хэрэгжүүлэх үндсэн чиглэл

3.3 Дотоод аудиттай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт: Нягтлан бодогчийн орон тоо байхгүй, хавсран ажиллуулдаг, ойр ойрхон өөрчлөн дотоод хяналтыг сулруулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3."Энэ хуулийн 19.1, 19.2-т зааснаас бусад тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нь төсвийн ахлах нягтлан бодогч, нягтлан бодогчтой байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл: Дотоод хяналт сулрах

3.3.3 Өгсөн зөвлөмж: Хуулийн заалтыг мөрдөж ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хуулийн заалтыг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөг/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,353,742.00	14,554,990.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
33	АВЛАГА	1,503,884.00	899,512.00
335	Бусад авлага	1,503,884.00	899,512.00
3351	Байгууллагаас авах авлага	268,628.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,235,256.00	899,512.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,849,858.00	13,655,478.00
351	Түүхий эд материал	00.00	00.00
354	Хангамжийн материал	12,849,858.00	13,655,478.00
35410	Бичиг хэргийн материал	1,283,600.00	816,540.00
35420	Аж ахуйн материал	7,743,580.00	7,735,580.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	299,183.00	00.00
35450	Барилгын засварын материал	00.00	00.00
35460	Хүнсний материал	00.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	3,523,495.00	5,103,358.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	43,750,415.35	45,843,792.41
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	43,750,415.35	45,843,792.41
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	43,750,415.35	45,843,792.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	00.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,900,000.00	23,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-55,844,444.32	-12,777,777.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,328,722.08	54,599,016.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-39,551,737.48	-41,928,314.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,867,492.70	51,305,582.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,949,617.63	-28,354,713.84
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	58,104,157.35	60,398,782.41
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	41,988.00	348,203.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	41,988.00	348,203.90
413	Өглөг	41,988.00	348,203.90
4136	Бусад өглөг	41,988.00	348,203.90
41361	Байгууллагад төлөх өглөг	41,988.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	00.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	00.00	65,733.90
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	00.00	282,470.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	58,062,169.35	60,050,578.51
51	Засгийн газрын хувь оролцоо	58,062,169.35	60,050,578.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	110,905,897.88	110,905,897.88
51101	Өмч: - төрийн	110,905,897.88	110,905,897.88
512	Хуримтлагдсан үр дүн	-52,843,728.53	-50,855,319.37
51210	Өмнөх үеийн үр дүн	-52,843,728.53	-52,843,728.53
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,988,409.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	58,104,157.35	60,398,782.41

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	749,387,422.88	817,458,707.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,878,222.88	13,760,907.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,878,222.88	13,760,907.00
120001	Хувьцааны ногдол ашиг	00.00	00.00
120002	Хүүгийн орлого	00.00	00.00
120003	Торгуулийн орлого	00.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,826,291.33	13,760,907.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	109,433.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	00.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	00.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,826,291.33	13,651,474.00
120009	Бусад орлого	2,051,931.55	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	741,509,200.00	803,697,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	726,509,200.00	773,697,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	726,509,200.00	773,697,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,000,000.00	30,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	00.00
131103	ЗГНХЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	00.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	750,959,491.90	815,222,797.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	750,959,491.90	815,222,797.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	750,109,502.08	814,569,582.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	602,964,240.92	627,311,107.00
210101	Үндсэн цалин	585,987,340.92	609,356,507.00
210102	Нэмэгдэл	00.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,976,900.00	17,954,600.00
210104	Урамшуулал	00.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,384,471.36	78,893,254.98
210201	Тэтгэврийн даатгал	72,384,471.36	78,893,254.98
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,590,965.00	21,462,703.80
210301	Гэрэл, цахилгаан	1,405,600.00	1,441,400.00
210302	Тулш, халаалт	9,313,005.00	9,176,115.00
210303	Цэвэр, бохир ус	1,045,800.00	1,365,508.80
210304	Байрны түрээс	7,826,560.00	9,479,680.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,539,424.04	18,664,676.50
210401	Бичиг хэрэг	4,013,150.00	5,723,240.00
210402	Тээвэр, шатахуун	7,046,654.00	6,451,611.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,424,559.04	1,833,174.50
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	689,800.00	750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,365,261.00	3,906,651.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,499,500.00	20,150,938.30
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00
210602	Тавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	8,499,500.00	20,150,938.30
2107	Томилот, зочны зардал	1,573,210.00	494,600.00
210701	Гадаад албан томилот	00.00	00.00
210702	Дотоод албан томилот	1,573,210.00	494,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын харъяа Тээврийн прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,936,243.00:	5,624,795.00:
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,739,100.00:	4,498,300.00:
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	988,443.00:	988,443.00:
210803	Даатгалын үйлчилгээ	00.00:	00.00:
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197,200.00:	138,052.00:
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00:	00.00:
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00:	00.00:
210807	Газрын төлбөр	00.00:	00.00:
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,500.00:	00.00:
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00:	00.00:
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	00.00:	00.00:
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	00.00:	00.00:
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	00.00:	00.00:
210813	Бусад зардал /ТӨҮГ/	00.00:	00.00:
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	00.00:	00.00:
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,621,447.76:	41,967,506.94:
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,900,000.00:	30,000,000.00:
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	700,000.00:	700,000.00:
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,021,447.76:	11,267,506.94:
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00:	00.00:
211	ХҮҮ	00.00:	00.00:
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	00.00:	00.00:
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	00.00:	00.00:
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	00.00:	00.00:
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	00.00:	00.00:
212	ТАТААС	00.00:	00.00:
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00:	00.00:
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00:	00.00:
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	00.00:	00.00:
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	00.00:	00.00:
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	849,989.82:	653,215.30:
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00:	00.00:
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00:	00.00:
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00:	00.00:
2132	Бусад урсгал шилжүүлэг	720,000.00:	500,000.00:
